



**“Хөх судар” романы
уран сайхны дүрслэл
ЗОХИОГЧЫН ҮЗЭЛ**



- Түүхэн үлгэрийн хэлбэрийг хосолсон өвөрмөц шинж бүхий зохиол юм.
- Их монгол улсын нэгдсэн төр байгуулагдсан үеийг түүхчлэн бичсэн
- Хөх судар нь оны тэмдэглэлт бичиг.
- Монголын уран зохиолын түүхэн дэх анхны түүхэн роман гэж үзэж болно.



Чингис хааны хойч ургийнхнаас Монголын түүх соёлын алтан хуудаснаа мөнхийн бүтээлээ үлдээсэн хүмүүний нэг нь тайж В.Инжинаш (Хашчулуу) болой.

Эцэг Ванчинбал нь "Их юань улсын мандсан төрийн хөх судар"-ыг эхлүүлэн бичиж 8 бүлэг тууривсаныг Инжинаш хожим нь үргэлжлүүлэн бичиж 69 бүлэг болгожээ.

Ванчинбалын хөвгүүдээс гарамгай яруу найрагч төрсөн бөгөөд бичгийн өндөр боловсролтой шүлэгчид байлаа. Монголын утга зохиолын түүхэнд эцэг Ванчинбалтайгаа нийлээд нэг айлаас таван бичгийн хүмүүн төрж, яруу найргийн үнэт өвийг хойч үедээ үлдээсэн нь бахархалтай хэрэг бөгөөд дэлхий утга зохиолын түүхэнд ч онцлон тэмдэглэвэл зохих үйл явдал мөн.

- "Хөх судар"-ын эхний 60 бүлэгт Чингис хааны үеийн хэрэг явдал, сүүлийн 9 бүлэгт Өгөөдэй хааны үе хүртлэх үйл явдлыг уран сайхны аргаар чимэглэн өгүүлсэн байна.
- Монголын эртний яруу найргийн зүйл, ерөөл магтаал нэлээд орсноос гадна ардын дууны зүйл ч бий.
- Романы гол дүрүүд Энэ романы гол баатрууд нь 13-р зууны үеийн монголын нийгмийн үндсэн анги талын феодал ядгууртан болон жирийн ард түмний төлөөлөгч болсон байна.

- Монголын 74-жилийн түүхийг хамарсан юм. Романы үйл явдал нь Чингис хаан Жамух хоёр Монгол ба алтан улс хоёрын хоорондын зөрчлөөр илрэнэ. Зохиолд Монголын тулгар төр байгуулагдсаны үеийн түүхийг уран сайханаар өгүүлнэ.
- Чингис түүний дөрвөн хүлэг баатрууд болох Мухулай , Боорчи, Борхул, Чулуун нарыг товойлгон дүрсэлж монголчуудын нэгдэлд саад болж байсан.

Инжинаш /1837-1892/

Инжинаш 1837 онд Өвөр монголын Зостын чуулганы Түмэд баруун хошуунд Ванчинбал гэгч угсаа залгамжилсан язгууртны гэр бүлд мэндэлжээ.

- "Их юань улсын мандсан төрийн хөх судар"" Нэгэндавхар асар", "Улаанаар уйлах танхим" романаа бичихдээ монгол үндэстнийхээ уран зохиол болох уран домог, түүхэн үлгэр, ардын дуу, ерөөл магтаал зэрэг уламжлалыг өвлөн авсан үндсэн дээр хань үндэстний эртний сонгодог уран зохиол тухайлбал "Гурван улсын үлгэр", "Хүйтэн уулын бичиг", "Баруунтаа зорчисон үлгэр" романуудын үзэл санаа, бүтэц зохиомж, зохион бүтээх арга барилын сор содон зүйлсээс суралцан авч ашигласан онцлогтой юм .
- 1892 онд 56 тайдаа отчийн сүмд үхсэн. хар луу жил




- Хөх судар"-ын олон хувилбарууд гар бичмэлээр болон гэрэл зургаар олон газар хадгалагдаж байгаагийн дотор манай Үндэсний төв номын санд 12 дэвтэр гар бичмэл буй.
- Тэрхүү гар бичмэлийг 1914 онд хошуу ноён Хурц ван Түвдэнгийн (одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын) хувийн номын сангаас Данзан гэгч хүн хуулан авсан гэж үздэг билээ.

- Судар бичгийн хүрээлэнгээс хориод онд Инжинашийн зохиолуудыг эрэн сурвалжиж байжээ.
- Энэ мэт Инжинашийн зохиолыг судлах, өвийг хамгаалах талаар хөөцөлдөж байсан мэдээ бий боловч үнэн хэрэгтээ энэ ажил өвөрлөгч эрдэмтэд болон, гадаадын монголч эрдэмтэдийн хэрэг байсаар өнөөг хүрчээ.

- арван найман бүлэгтэй хоёр бар хэвлэл буюу хоёр дэвтрээр уншигч олны гар дээр очсон нь эх хувилбар буюу анхны хэлбэрээрээ байжээ.
- хоёрдахь хэвлэл нь 1990 онд В. Инжинаш << Их юань улсын мандсан төрийн хөх судар >> гэсэн гурамсан романыг хураангуйлан хөх судрын үлгэр номыг Ө.М.Ө.З.О ын хэвлэлийн уран бичгийн найруулах тасгаас Б.Хянган манай орчуулагч Ц. Сүхбаатар эрдэмтэн Г.Хасбаатар монгол бичгээс крилл үсэгт буулгаж уг эхийг тулган нэг дэвтэр бүхий дөчин гурван бүлэгтэйгээр хэвлэгджээ



- 
- Тухайн үеийн чин улсын зүгээс Монгол үндэстний гадаад ертөнцөөс хөндий байлгах гэсэн бодлого нь хэвээр үргэлжилж байсан цаг үе агаад эх орны үндсэрхэг үзэл манж чингийн уланд гишгэгдэж улс үндэстний үнэт зүйлс алдагдаж байгааг өөрийн амьдарч буй нийгэмтэй нь ижил учир мах ясандаа шингээсэн.
 - Тэр үеийн Хятадын үймээн нь Инжинашын язгууртан гэр бүлд нөлөөлсөн нь Инжинаши нь Ромео Жульята хэмээх алдарт зохиолоо шикспер өөрөө дурласан үедээ бичсэн гэдэгтэй агаар нэгэн адил байна. Энэ нь зүрх сэтгэлээсээ гүн гүнзгий ойлгож байгаад оршино.

Жишээ 1 :

*** нэгэн төрлийн баян ядуу хоёр туйлтын тэмцэлдээн, амьдрал мөхлийн зам ч өөр өөр ашиг сонирхол шунал хүслийн эрэлт уналт ч алсдаа харилцан адилгүй.Эүдэгээ цаг доор харгис түшмэл хоцдог ноёд улсаар дүүрэн буй

Тайлбар :

шүүмжлэхдээ

хэмээн бичсэн нь түүхийн аль ч цаг үед байснаар үл барам одоо ч хэрнээ байсаар байгаа нийгмийг улс төрийн буруу тоглтолцоог бүрдсэн хэмээх бүрэн үндэслэлтэй.

Жишээ 2 :

- “Дөрвөн харь таван өнгийг хуваасан нь”

(сүүлийн дөчин гуравдугаар бүлгээс)

“Дөрвөн харь таван өнгийг хуваасан нь”
(учир зүйн талаас)

Тайлбар :

- Эрт дээр үеэс(эцгээс үүсч, эхээс төрсөн өдөрт баясгалангын ёсоор тавиглан хуримлан жаргавал зохино) хэмээсэн нь нас сүүдэр нэмсэний найр буюу орчин цагаар бол төрсөн өдрийг тэмдэглэдэг байсны нэгэн нотолгоо болно.
- Харин нь Дэлхийн талыг эзлэн суусан чингис хаан нэгтгэсэн усаатараан бутраахгүйн тулд таван хэсэг буюу дөрвөн зүг найман зовхист бүлэглэн хувааж дөрвөн хөвүүндээ хуваан даатгаж байгаа нь тэр ажээ.


Жишээ 3 :

- БИЧИГ СУДАР

- ~~Сургах ба дуурайх **БИЧИГ СУДАР** үгүй атал хувьдаа сурсан явдал үзэл тул төрөлх богдод орсон буюу.

Тайлбар :

Хэдий эрдмийг номоор дамжин суравч аливаа зүйлсийг хүрээлэн буй орчингоосоо суралцаж болдог гэсэн санааг илэрхийлж байна.




Зохиогчийн "Хөх судар"-ыг бичсэн гол зорилгыг эрдэмтэн мэргэд тайлахдаа:

- ❖ монголын ноёд тайж нараас үндэс язгуураа бодолгүй эд ашгийн боол болж, монгол тоотны дийлэнх үндэстнийхээ түүхийг мэдэхгүй, үндэстэнээ голж жигших үзэл буй болж байсныг шүүмжлэн сэнхрүүлж, үндэстнээ хайрлах сэтгэлийг буй болгох
- бүх монгол тоотондоо уг түүхийг нь мэдүүлж, улмаар хойч үеийнхэнд уламжлан хоцоргохыг зорьсонтухайн үеийн монгол үндэстнийг мунхаг бядуу хэмээн гадуурхан басамжилж байсан харийнханы доромжлолыг эсэргүүцэж, үндэстнийхээ цог сүлдийг мандуулах




Өчүүхэн миний ухаанд...

- ❖ харь үндэстний бичиг зохиолд монголын түүх, заншлыг гуйвуулан тэмдэглэсээр ирснийг няцааж залруулах
- ❖ бүх монгол тоотондоо уг түүхийг нь мэдүүлж, улмаар хойч үеийнхэнд уламжлан хоцоргохыг зорьсон



Өчүүхэн миний ухаанд...

Т.Галсан

- Монгол хүмүүний зүрхний бичээс
 - Би таван ханатай гэрт төржээ
 - Би таван тивтэй дэлхийд төржээ
 - Би буурал түүхтэй Монголд төржээ
 - Би бурхад мэндэлдэг дорнодод төржээ
 - Эвдэрвээс бид хуваахын хүрд
 - Эвлэрвээс бид үржүүлэхийн хүрд
 - Эвдэрвээс бид чин улсын босгоны боол
 - Эвлэрбээс бид чингисийн бүрэн гүрэн Монгол
- 

Ашигласан ном зүй

- Хөх судрын үлгэр Б.Хянган /2000/
- Хөх судрын товхимол Л. Хашхүү /1998/
- Уран зохиол шинжлэлийн лекц Г.Галбаяр /1994/
- Хэлний найруулга зүй О. Баасанбат /2002/
- Монголын уран зохиолын дээжис боть-7
- Монголын уран зохиолын дээжис боть-11



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯАРЛАЛАА

11А ангийн сурагч Э.Бадам

